



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2017/11



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)



## **ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

(2017 оны 11 дүгээр сарын байдлаар)

### **Нэг. Нийгмийн үзүүлэлт**




#### **1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2017 оны эхний 11 сард 1199 эх амаржиж, 1204 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буюу 143-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буюу 148-аар буурсан байна. 2017 оны 11 сарын байдлаар 315 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буюу 24-өөр буурчээ.

Хүн амын цэвэр өсөлт 889 болж 2016 оны мөн үеийнхээс 12.2 хувиар буюу 124-өөр буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 18.6, нас баралт 4.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 2.8 пунктээр, нас баралт 0.5 пунктээр тус тус буурсан байна.

*Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2014-2017 оны эхний 11 сард*



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл 10.8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр буурчээ.



#### **1.2 Эрүүл мэнд**


Он гарсаар 314.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар, 12.3 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буурч, 14.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар илүү байна.

Эхний 11 сард 1417 эх жирэмсний хяналтанд орсны 86.2 хувь буюу 1222 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.7 пунктээр нэмэгдсэн байна.

Түргэн тусламжийн дуудлага 16.8 мянган удаа гарсны 2.2 мянга буюу 13.1 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 8.7 хувиар, алсын дуудлага 31.3 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 2397 хүн бэртэж, 79 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 238 (11.0%), нас барсан хүний тоо 5 (6.8%) хувиар тус тус нэмэгджээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2017 оны эхний 11 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 23.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 26.3 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 25.1 хувь, хоол шингээх эрхтний өвчин 7.6 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 2.9 хувь, бусад шалтгаан 14.6 хувийг эзэлж байна.

Халдварт өвчний 631 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 61.8 хувиар буюу 1019-өөр буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад тэмбүү 37.4 хувь, вируст гепатит 35.7 хувь, заг хүйтэн 15.3 хувь, трихоминиаз 15.6 хувь, бусад төрлийн халдварт өвчин 79.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.



### 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны 11 сарын эцэст 1178 болсны 1148 (97.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 30 (2.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.


Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 150 (11.3) хүнээр өсч, өмнөх сараас 134 (10.2%) хүнээр буурч 1178 болсны 602 (51.1%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 647 (54.9%) нь Сайншанд суманд, 216 (18.3%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 53.2 хувь нь бүрэн дунд, 23.8 хувь нь дээд, 5.5 хувь нь бүрэн бус дунд, 6.5 хувь нь тусгай дунд, 8.5 хувь нь техник



болон мэргэжлийн, 0.7 хувь нь бага, 1.3 хувь нь боловсролгүй, 0.5 хувь нь магистр/докторын, иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2017 оны 11-р сард



Хөдөлмөрийн хэлтэст 2017 оны 11-р сард 1258 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 582 иргэн ажилд зуучлагдан орж, 566 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн 415 (24.8%) хүн буурч, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 429 хүнээр өсч, ажилд зуучлагдан орсон иргэд 568 хүнээр нэмэгдсэн байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 707 ажлын байрны 17.4 хувь нь мэргэжилтэн, 1.6 менежер хувь, 12.3 хувь худалдаа, үйлчилгээний ажилтан, 18.8 хувь нь энгийн ажил, 15.9 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 5.0 хувь нь контор үйлчилгээ, 17.4 техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 11.6 хувь нь бусад ажилтны захиалга байна.

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар




Ажил хайгч 582 иргэн ажилд зуучлагдан орсоны 221 (38.0%) нь эмэгтэйчүүд байна.



#### 1.4 Нийгмийн даатгал, халамж


Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 11 сард 25168.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2949.9 (13.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 2949.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд Тэтгэврийн даатгал 1562.8(11.6%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 182.9 (12.1%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 566.8 (29.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 328.2(91.3%) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2017 оны 10 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 36174.5 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2946.4 (8.9%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 25409.5 сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2013.9 сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5740.0 сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2152.1 сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 859.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас оны эхний 11 сард нийгмийн халамжийн сангаас 17943 иргэнд 5412.4 сая төгрөгийн халамжийн




тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд -1786 (9.1%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 443.3 (8.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2017 онд 1417 хүн хамрагдсан нь өмнөх оноос 318 (18.3%)-аар хасагдаж, олгосон тэтгэвэрийн хэмжээ 126.1 (7.3%) мян төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1246 иргэнд 656.5 мянган төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 1238 иргэнд 493.9 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 283 иргэнд 18843 мян төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 6668 иргэнд хамруулж 1338.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийг 7091 иргэнд 1046.6 сая төгрөг олгон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/



### 1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 11 сарын байдлаар 625 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 200 хүн гэмтэж, 33 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 25 (4.2%)-аар нэмэгдсэн, нас барсан хүний тоо 3 (10,0%)-аар нэмэгдэж, гэмтсэн хүний тоо 60 (23,1%) -аар буурсан байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 56 (26.7%)-аар, авилгын гэмт хэрэг 18 (85.7%)-аар буурч бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 30.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 24.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 35.5 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 152 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.2 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд сумдад буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 4360,3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2441,8 (2.2 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлын 2607,6 (59,8%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 192 (30.7%) нь гэр сууцандаа, 152(24.3%) нь согтуугаар, 99 (15.8%) нь гудамж олон нийтийн газарт, 58 (9,3%) бүлэглэн, 104 (16.6%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 202 (32.3%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1460 хүн саатуулагдаж, 196 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 11 сард





## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



### 2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 1057.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 18.4 хувь, цэвэр зарлага 997.5 тэрбум төгрөг болж 46.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2016- 2017 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2016-2017 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 76.1 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1133.9 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1142.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 2.1 (3.2%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 19.1 (33.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 11 дүгээр сарын эцэст 3736.8 сая төгрөг болж, өмнөх сараас 1233.1 (50.7%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1513.4(68.1%) сая төгрөгөөр нэмэгдэжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдэлийн 1.9 хувийг эзэлж, өмнөх сараас 0.6 пунктээр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 11 дүгээр сарын эцэст 7209.6 сая төгрөг болж өмнөх сараас 710.9 (9.0%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2058.4 (22.2%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2017.11 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2017.11 сард



## 2.2 Орон нутгийн төсөв

2017 оны 11 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 20792.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 94.5 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 49.4 хувиар буурсан байгаа нь улсын төсвөөс санхүүждэг тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих зардлын эх үүсвэрүүд 2017 оноос орлогын гүйцэтгэлийн дүнд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой юм. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 79.0 хувийг татварын, 21.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2017 оны 11-р сард





Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 4379.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 2072.9 (89.9%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 879.8 (1.2 дахин) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2017 оны 11 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурчээ.

**Ерөнхий индекс өмнөх сараас 0.3 хувиар буурахад:** хүнсний бараа, ундаа усны бүлэг 1.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг, 0.8 хувь, гэр ахуйн тавилга, бараа, 1,4 хувь, тээвэр 0.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.


Хэрэглээний үнийн индексийн бусад бүлэг буюу согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 2.1 хувь, хувцас, бөс бараа 0.4 хувь, эм тариа, эмнэлэгийн хэрэгсэл 8,2 хувиар нэмэгдсэн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 11 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)





Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 11 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 11 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 76.5 хувь буюу 585.8 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 88.2 (24.9%) мянган толгойгоор, төл бойжилт 117.2 (24.9%) мянган толгойгоор илүү юм.

2017 оны 11 сарын байдлаар 2224 толгой мал хорогдсоны 59.5 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Нийт хорогдолын 62.7 хувь нь Дэлгэрэх, Сайншанд суманд гарчээ.


Том малын зүй бус хорогдол 2017 оны 11-р сарын хэмжээнд 2.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 95.5 (97.7%) мянган толгойгоор буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзэхэд адуу 43 толгой, үхэр 258 толгой, тэмээ 31 толгой, хонь 1426 толгой, ямаа 466 толгой байна. Нийт хорогдсон малын 64.1 хувийг хонь, 20.9 хувийг ямаа эзэлж байна.

2017 оны 11-р сарын байдлаар 122.3 га талбайд тариалалт хийснээс төмс 30.9 га-д, хүнсний ногоо 67.4 га-д, тэжээлийн ургамал 10.5 га-д, техникийн ургамал 0.06 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт тариалсан талбай 30 (32.5%) га, үүнээс тэжээлийн ургамлынх 3.6 (52.2%) га-гаар нэмэгдэж, төмс тариалсан талбай 8.1(24.0%) га, хүнсний ногоо 2.6 (5.1%) га-гаар буурсан байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 11-р сард ноолуурын дундаж үнэ 60000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20000 (66.7%) төг, өөр өссөн байна. Харин ингэний сүү 2500 төг, тэмээний шир 5.0, адууны шир 15.0, хонь, ямааны арьс 15.0 мянган төг-ийн ханштай байна. Эр хонь 110.0-150.0 мян.төг, эр ямаа 70.0-120.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



Зураг. Том малын зүй бусын хорогдол, толгой



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 11 сард аж үйлдвэрийн салбарт 141280.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 234922.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.0 дахин, борлуулалт 21.3 дахин тус тус өссөн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын өсөлтөд нүүрс олборлолт, цементний үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.1 хувийг төрийн, 95.9 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.1 хувь, компани 95.5 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 2.9 мян.ккалаар, талх 6.6 мян.тонноор, сүүн бүтээгдэхүүн 21.9 мян.литрээр, хиам 0.8 тонноор, хэрчсэн гурил 7.9 мян.тонноор, цемент 273.1 мян.тонноор, модон эдлэл 11733.4 мян.төгрөгөөр, жижиг оёдол 594.0 мян.төгрөгөөр, вакуум цонх 750.1 м2-аар, бялуу 1.1 тонноор, нүүрс 1161.0 мянган тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин Цаг уур

2017 оны 11 дүгээр сард агаарын дундаж температур нийт сумдын нутгаар 6.3-8.0 хэм хүйтэн байлаа. Агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдын нутгаар 12 – 17 хэм дулаан байлаа. Нийт нутгаар ОЖД-аас дулаан байсан. Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас 1.1-2.1 хэм хүйтэн байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө нутгийн хойд хэсгээр 27-30 хэм хүйтэн, бусад сумдын нутгаар 20-25 хэм хүйтэн, өдөртөө нийт сумдын нутгаар 21- 25 хэм дулаан байв.

11 дүгээр сард нийт сумдын нутгаар 2-9 өдөр 0,2-6,1 мм хур тунадас орж сарын нийлбэр хамгийн их тунадас Алтанширээ суманд 6,1 мм байв.

\_\_\_\_\_ о Оо \_\_\_\_\_



## АГУУЛГА

### II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

#### Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

#### Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6 Шинээр бий болгосон ажлын байр, эдийн засгийн салбарын ангилалаар

#### Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

#### Дөрөв. Гэмт хэрэг

- 4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

#### Тав. Мөнгө, зээл

- 5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 5.2 Ипотекийн зээл, сарын эцэст
- 5.3 Хадгаламж, зээл, сумаар, 7 сарын эцэст

#### Зургаа. Орон нутгийн төсөв

- 6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 6.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

#### Долоо. Үнэ

- 7.1 Хэрэглээний үнийн индекс
- 7.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

#### Найм. Хөдөө аж ахуй

- 8.1 Мал төллөлт, төл бойжилт
- 8.2 Том малын зүй бус хорогдол
- 8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 8.4 Малын үнийн судалгаа, сумаар

#### Ес. Аж үйлдвэр

- 9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

#### Арав. Байгаль орчин

- 10.1 Цаг уурын үзүүлэлт

#### Тэмдэглэлийн тайлбар :

- ( ,, ) - тухайн тоо, баримт байхгүй
- ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- ( х ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2017 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2017 - 2016	2017
							хувь
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.5	63.1	64.0	67.5	3.5	105.5
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	1257	1297	1352	1204	-148	89.1
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	308	275	339	315	-24	92.9
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	949	1022	1013	889	-124	87.8
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	15	17	20	13	-7	65.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	11.9	13.1	14.8	10.8	-4.0	73.0
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	712	733	1650	631	-1019	38.2
- 10000 хүнд ногдох	тоо	112.1	116.1	248	93	-154	37.7
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 131	1 235	1 328	1 178	- 150	88.7
- Үүнээс эмэгтэй	тоо	879	721	733	602	- 131	82.1
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	370	299	332	278	- 54	83.6
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	851	883	443	580	137	130.9
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	675	883	333	580	247	174.2
Улирлын чанартай ажлын байр	тоо	176	0	110	98	-12	89.1
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	444	508	600	625	25	104.2
- 10000 хүнд ногдох ***	тоо	106.7	122.1	140.9	145	5	103.2
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	500.0	532.4	469.5	586.7	117	125
- Унага	толгой	19.6	19.9	12.8	21.6	9	169
- Тугал	толгой	16.4	17.5	12.8	16.6	4	130
- Ботго	толгой	5.5	6.0	6.0	6.7	1	112
- Хурга	толгой	227.0	250.3	236.6	286.9	50	121
- Ишиг	толгой	231.5	238.7	201.3	254.9	54	127
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	9078.0	8478.9	15689.4	141280.2	125590.8	9.0 <sup>2</sup>
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	11066.0	8400.6	11049.5	234922.4	223872.9	21.3 <sup>2</sup>

\* - 2013, 2014, 2015, 2016 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 11 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-XI	2017 I-XI	Өсөлт	
		тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	363.1	314.3	-48.8	86.6
2. Ор хоног	мян.хүн	103.3	103.1	-0.2	99.8
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	13.7	12.3	-1.4	89.8
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	14.4	14.5	0.1	100.7
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	18.4	16.8	-1.6	91.3
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	3.2	2.2	-1	68.8
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2159	2397	238	111.0
Үүнээс: нас баралт	хүн	74	79	5	106.8
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1316	1417	101	107.7
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1126	1222	96	108.5
8. Амаржсан эх	хүн	1342	1071	-271	79.8
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	1	-1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	20	13	-7	65.0

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 11 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
тоо					
Дүн	1199	0	1204	13	1
Айраг	3		3	1	
Алтанширээ					
Даланжаргалан	1				
Дэлгэрэх	2		1		
Иххэт	2		2		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3		
Хөвсгөл	3		2		
Эрдэнэ	1				
Сайншанд	943		951	6	1
Замын - Үүд	241		242	6	

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 11 сарын эцэст

Үзүүлэлт	2016 I-XI	2017 I-XI	Өсөлт	
	Тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	1650	631	-1019	38.2
Вируст гепатит	14	9	-5	64.3
Сүрьеэ	76	82	6	107.9
Тэмбүү	131	82	-49	62.6
Заг хүйтэн	131	111	-20	84.7
Трихоминиаз	82	70	-12	85.4
Цусан суулга	18	35	17	194.4
Бусад	1198	242	-956	20.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



*Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга*  
**ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

**2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮИ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 11 сарын эцэст**

Боловсролын түвшингээр	2014 XI	2015 XI	2016 XI	2017 XI	$\frac{2017 \text{ XI}}{2014 \text{ XI}}$	$\frac{2017 \text{ XI}}{2016 \text{ XI}}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1 131	1 235	1 328	1 178	104.2	88.7
Үүнээс: Эмэгтэй	879	721	733	602	68.5	82.1
Магистр, доктор	7	6	9	6	85.7	66.7
Дээд боловсролтой	381	305	353	280	73.5	79.3
Тусгай дунд	76	160	134	77	101.3	57.5
Техник мэргэжлийн	74	128	143	100	135.1	69.9
Бүрэн дунд	337	451	488	627	186.1	128.5
Бүрэн бус дунд	200	145	163	65	32.5	39.9
Бага	48	33	27	8	16.7	29.6
Боловсролгүй	8	7	11	15	187.5	136.4

**2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 11 сарын эцэст**

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2016 XI	2017 XI	2016 XI	2017 XI	2016 XI	2017 XI
ДҮН	1328	1178	315	582	1673	1258
Айраг	63	50	24	51	94	77
Алтанширээ	16	21	0	16	54	22
Даланжаргалан	56	46	12	58	65	71
Дэлгэрэх	22	24	41	16	54	34
Иххэт	37	30	14	3	48	21
Мандах	62	13	2	24	35	50
Өргөн	87	31	21	46	69	79
Сайхандулаан	41	17	3	9	43	42
Улаанбадрах	44	14	46	55	73	50
Хатанбулаг	33	35	11	9	88	49
Хөвсгөл	17	12	17	16	46	34
Эрдэнэ	19	22	22	38	57	51
Сайншанд	596	647	68	189	655	496
Замын - Үүд	235	216	34	52	292	182

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал 2017 оны 11 сарын эцэст

Салбарын ангилал	2016 XI	2017 XI
	Тоо	
Бүгд	31	707
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	2	12
Уул уурхай олборлох аж үйлдвэр	3	374
Боловсруулах үйлдвэрлэл		5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	7
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		5
Барилга	0	1
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0	1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	0	0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0	0
Мэдээлэл, холбоо	0	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	10
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0	5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2	57
Боловсрол	0	36
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	9	27
Урлаг, үзвэр,тоглоом наадам	0	9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	13	157
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал 2017 оны 11 сарын эцэст

Үзүүлэлт	2016 XI	2017 XI
	Тоо	
Бүгд	31	707
Менежер	0	11
Мэргэжилтэн	2	123
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	0	123
Контор, үйлчилгээний ажилтан	5	35
Худалдаа, үйлчилгээний ажилтан	0	87
ХАА, ой загас агнуурын ажилтан	2	3
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	0	73
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, үгсрагч	0	113
Энгийн ажил мэргэжил	22	133
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0	6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

## 2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 11 сарын эцэст

Үзүүлэлт	2016 XI		2017XI	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	315	128	582	221
Менежер	16	10	10	3
Мэргэжилтэн	112	56	70	52
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	17	10	109	50
Контор, үйлчилгээний ажилтан	13	11	26	23
Худалдаа, үйлчилгээний ажилтан	68	27	69	53
ХАА, ой загас агнуурын ажилтан	4	0	2	1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	37	7	57	9
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	17	0	115	8
Энгийн ажил мэргэжил	27	5	119	21
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	4	2	5	1

## 2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 11 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	580	170	502	78
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	0	1	
Уул уурхай олборлолт	358	88	355	3
Боловсруулах үйлдвэрлэл	37	7	37	
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	6	3	6	
Барилга	81	21	20	61
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	5	1	5	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	3	1	3	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1	0	1	
Мэдээлэл холбоо	0	0	0	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0	
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	0	3	
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	11	0	11	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	13	3	12	1
Боловсрол	40	35	39	1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	8	3	4	4
Урлаг үзвэр тоглоом наадам	1	0	1	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11	7	3	8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 11 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2017 I-XI 2016 I-XI
	2016 I-XI	2017 I-XI	
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	22 218.6	25 168.5	113.3
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	13 430.8	14 993.6	111.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	1517	1 699.9	112.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4994.7	5 303.9	106.2
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1916.8	2 483.6	129.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	359.3	687.5	191.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага	33228.1	36174.5	108.9
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	24 267.1	25 409.5	104.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	2 037.0	2 013.9	98.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 924.1	5 740.0	116.6
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 318.7	2 152.1	163.2
Ажилгүйдлийн даатгалын сангийн	681.2	859.0	126.1

\*\* - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 11 сарын эцэст

Үзүүлэлт	хэмжих нэгж	2016 I-XI	2017 I-XI	2017 I-X 2016 I-X
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	15593	17172	110.1
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7354	8470	115.2
Төсөвт байгууллага	тоо	8239	8702	105.6
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	24072.4	26181.0	108.8
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	17455.7	19170.3	109.8
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	2804.9	2839.5	101.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	1234.8	1333.6	108.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	817.4	779.9	95.4
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1759.6	2057.7	116.9

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



## 4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		Олгосон тэтгэвэр тэтгэмж		2017-ХI 2016-ХI	
	2016 I-XI	2017 I-XI	2016-ХI	2017 I-XI		
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>19729</b>	<b>17943</b>	<b>90.9</b>	<b>4969156.7</b>	<b>5412438.7</b>	<b>108.9</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1735</b>	<b>1417</b>	<b>81.7</b>	<b>1731688.0</b>	<b>1857760.3</b>	<b>107.3</b>
Ахмад настны тэтгэвэр	0	59		0.0	75925.0	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	0	1358		0.0	1781835.3	
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1359</b>	<b>1246</b>	<b>91.7</b>	<b>649713.5</b>	<b>656544.6</b>	<b>101.1</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч	1276	1170	91.7	604897.6	612304.9	101.2
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	56	55	98.2	33762.4	34625.0	102.6
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	8	8	100.0	2226.7	3694.9	165.9
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	19	8	42.1	8826.8	3699.0	41.9
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		5			2220.8	
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>1598</b>	<b>1238</b>	<b>77.5</b>	<b>509162.2</b>	<b>493936.9</b>	<b>97.0</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	224	240	107.1	275782.2	307756.9	111.6
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	1248	888	71.2	154140.0	125580.0	81.5
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	67	71	106.0	8040.0	7800.0	97.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	20	17	85.0	28000.0	30000.0	107.1
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	9	6	66.7	9600.0	6000.0	62.5
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	23	16	69.6	25200.0	16800.0	66.7
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	7	0	0.0	8400.0	0.0	0.0
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>	<b>57</b>	<b>283</b>	<b>496.5</b>	<b>8241.3</b>	<b>18843</b>	<b>2.3<sup>2</sup></b>
